


“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн
А/108 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГИШҮҮДИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

(шинэчилсэн найруулга)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн /цаашид МХБ гэх/ гишүүн үнэт цаасны компани болон гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан компанийн /цаашид ҮЦК гэх/ нийт ажилтнууд биржтэй харилцахад баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. МХБ-ийн гишүүн болон гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан ҮЦК-ийн ажилтны /цаашид ажилтан гэх/ ёс зүйн дүрмийн үндэс нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудын хэм хэмжээ, зарчим байна.

1.3. Ажилтан нь Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дүрэм, журам болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны “Монголын үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх эрх авсан мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм, мэргэжлийн үйл ажиллагааны стандарт” гэх ёс суртахууны нийтлэг шаардлагаас гадна энэхүү дүрэмд тодорхойлсон ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөж ажиллах үүрэгтэй.

1.4. Ажилтан албан үүргээ гүйцэтгэх болон бусад ямар ч үед энэхүү дүрмийг бүрэн биелүүлж, өөрийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалж ажиллах үүрэгтэй.

Хоёр. Ёс зүйн нийтлэг зарчим

2.1. Ажилтан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 25.1-д заасан зарчим, үйл ажиллагаандаа мөрдвөл зохих холбогдох журам, заавруудыг чанд мөрдөж ажиллахаас гадна ёс зүйн дараах зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

а. Шударга байх: “Үнэт цаасны зах зээлийн оролцогчидтой харилцахдаа шударга, хичээнгүй хүндэтгэлтэй байх”,

б. Хариуцлагатай байх: “Үнэт цаасны зах зээлийн нэр хүндийг тэргүүнд тавьж, шударга бус байдалтай үл эвлэрэн, үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ямагт өмнө тавих”,

в. Мэргэшсэн байх: “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах”.

Гурав. Ёс зүйн хэм хэмжээ

3.1. Ажилтан нь энэхүү дүрмийн 2.1. “а” дахь хэсэгт заасан ёс зүйн зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

3.1.1. Аливаа асуудлыг шийдвэрлэхэд байнга зөвийг эрхэмлэн дээдлэх,

3.1.2. Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх,

3.1.3. Ажилтан нь хүний эрх, эрх чөлөө, халдашгүй дархан байдлыг хүндэтгэн, бусдыг аливаа зүйлээр ялгаварлан гадуурхахгүй байх,

3.1.4. Ажилтан нь эрх бүхий байгууллагаас хяналт, шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, баримт материал хүсэхэд саад учруулалгүй, заасан хугацаанд гаргаж өгөх,

3.1.5. Ажилтан нь үйлчлүүлэгчидтэйгээ шударга харилцах үүрэгтэй ба тэдний хууль ёсны ашиг сонирхлыг байгууллагынхаа болон өөрийн хувийн эрх ашгийн ямагт өмнө тавих ёстой.

3.2. Ажилтан нь энэхүү дүрмийн 2.1.“б” дэх хэсэгт заасан ёс зүйн зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

3.2.1. Ажилтан нь өөрт олгогдсон нууцын зэрэглэлтэй материал, байгууллагын сүлжээ, системд нэвтрэх нэр, нууц үгээ бусдад дамжуулж задруулахгүй байх,

3.2.2. Ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх,

3.2.3. Олон нийтийн хүртээл болгоогүй аливаа мэдээ, мэдээлэл болон хувь хүнтэй холбоотой мэдээ, мэдээлэл тараахгүй байх,

3.2.4. Олон нийтийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр ажилтны хэлэх үг, нийтлүүлэх өгүүлэл, материал нь үнэт цаасны зах зээлийн нэр хүнд, бие даасан байдалтай харшлахгүй байх,

3.2.5. Өөрийн үзэл бодол, таамаглалаа МХБ-ийн бодлого, байр суурь хэмээн хамт олон, иргэд, олон нийтэд ухуулах, мэдээлэхгүй байх,

3.3. Ажилтан нь энэхүү дүрмийн 2.1.“в” дэх хэсэгт заасан ёс зүйн зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

3.3.1. Зах зээлд оролцогч болон хөрөнгө оруулагчдад аливаа мэдээлэл хүргэхдээ мэргэжлийн өндөр түвшинд судалж, санал, дүгнэлт, танилцуулга боловсруулах, үндэслэлтэй, үнэн зөв, бодит мэдээллээр хангах,

3.3.2. Эзэмшсэн мэдлэг мэргэжлээ дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэхэд анхаарах.

3.3.3. Ажилтан нь өөрийн бүхий л мэдлэг, боловсролоо дайчлан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхийн төлөө ажиллах,

Дөрөв. Ажилтан биеэ зөв зохистой авч явах

4.1. Ажилтан харилцан бие биенээ болон бусдыг хүндэтгэж, өөр хоорондоо шударга, найрсаг, ажил хэрэгч харилцаатай байна.

4.2. Ажилтан албан үүргээ гүйцэтгэж байх үедээ цэвэр цэмцгэр, төлөв, албаны ажил хэрэгч хувцасласан байна.

4.3. Ажиллаж буй орчноо хог хаягдалгүй цэвэр, цэмцгэр байлгах, байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийг хэмнэлттэй, үр ашигтай ашиглана.

4.4. Ажилтан нь хоорондоо болон бусад байгууллага, хувь хүн, үйлчлүүлэгчтэй өндөр, чанга дуугаар маргалдах, гүтгэх, нэр хүндийг гутаан доромжлох, бүдүүлэг үг, хэллэг хэрэглэх, сэтгэл санааны болон аливаа зүй бус дарамт учруулах зэргийг хориглоно.

4.5. Ажлын байранд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

4.5.1. Ажлын цагаар нийлж хувийн яриа дэлгэх, албан хэрэгцээний телефон утсаар хувийн асуудлыг удаан хугацаагаар ярих,

4.5.2. Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, ийм байдалтай ажил, үйлчилгээ үзүүлэх,

4.5.3. Ажлын орчиндоо саад болох, чимээ шуугиан гаргах,

4.5.4. Бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авч ашиглах, эвдэх, сүйтгэх.

4.6. Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглоно.

4.7. Бусад ажилтнуудын үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, нөлөөлөхийг оролдох, хүсэлт тавих, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.

4.8. Ажил үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бэлэг дурсгал, шагнал урамшуулал, мөнгөн хөрөнгө, эд зүйл, өөрт ашигтай туслалцаа болон хуулиар хориглосон бараа материал бусдаас авахыг хориглоно.

Тав. Бусад

5.1 “Монголын хөрөнгийн биржийн гишүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн тохиолдолд “Гишүүнчлэлийн журмын дагуу хариуцлага тооцно.

5.2. Гишүүнээр элсэхээр хүсэлтээ гаргасан байгууллага, түүний ажилтан нь ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд элсүүлэхээс татгалзах ба энэ тухай дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж болно.

-----oO-----